



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 16 өдөр

Дугаар А/53

Хатан суудал

Г Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12, 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бага баян 3 дугаар багийн нутаг “Зургаан худаг” хэмээх газарт Өмнөговь аймгийн “Ноен” сумын малчин Д.Отгончулууны малд Шүлхий өвчний сэжиг бүхий шинж тэмдэг илэрсэн тул тухайн нутаг дэвсгэрт 2022 оны 05 дугаар сарын 16-ны өдрөөс 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

2.Өвчилсөн мал, хашаа хороонд ариутгал халдваргүйжүүлэлт, мал сүрэгт тогтмол үзлэг хийхийг “Хар ботго” мал эмнэлгийн Малын эмч (Г.Ерөөлт)-д үүрэг болгосугай.

3.Өвчин гарсан нутаг дэвсгэрийн малын шилжилт хөдөлгөөн, хязгаарлалтын дэглэмд хяналт тавьж ажиллахыг Бага баян 3 дугаар багийн Засаг дарга (С.Ганхүлэг), Мал эмнэлгийн улсын байцаагч (Н.Цэрэндолгор) нарт хариуцуулсугай.

4.Мал өвчилсөн нутаг дэвсгэр, айл өрхөд хүрч ажиллах хүн хүч, бензин шатахууныг шийдвэрлэн удирдлагаар хангаж ажиллахыг Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)-д үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Ж.Энхбат)-д даалгасугай.

ДАРГА  О.МӨНХБАТ



642201027